



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/484

Улаанбаатар хот

**Нийслэлийн Хүрээ амаржих газрын
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 165,490,915 /нэг зуун жаран таван сая дөрвөн зуун ерэн мянга есөн зуун арван таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн Хүрээ амаржих газар /А.Жаргал/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 1,059,705 /нэг сая тавин есөн мянга долоон зуун таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 11 нэр төрлийн 164,431,210 /нэг зуун жаран дөрвөн сая дөрвөн зуун гучин нэгэн мянга хоёр зуун арван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Хүрээ амаржих газар /А.Жаргал/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115050001215

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 09 дүгээр сарын 30 ны өдрийн
Хяналт тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хүрээ амаржих газар

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	Мэргэжилтний санал	ЭБХХК-ийн хурлын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж													
1	Тог тохируулагч	5	ш	2	467 500.00	935 000.0	935 000.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
2	Эхо аппарат 3/4D /CB Fazone/, Япон	7	ш	1	158400000	158 400 000.0	158 400 000.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
3	Нярайн шарлагын аппарат	3	ш	1	500 000.00	500 000.0	500 000.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
4	Компьютер /Dell/	8	ш	1	989 000.00	989 000.0	989 000.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
5	Компьютер /Dell/	6	ш	1	1 021 900.00	1 021 900.0	1 021 900.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
6	Принтер /Samsung/	6	ш	1	137 500.00	137 500.0	137 500.0	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн						161 983 400.0	161 983 400.0	-					
Тавилга, эд хогшил													
7	Угаалгын машин /Sharp/	7	ш	1	469 990.00	469 990.00	469 990.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
8	Зурагт /Монел/	15	ш	1	280 214.00	280 214.00	280 214.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
9	Сандал	19	ш	6	83 576.00	501 456.00	501 456.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
10	Хос ширээ сандал	10	ш	1	220 400.00	220 400.00	220 400.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
11	Хувцасны шүүгээ	19	ш	1	372 111.00	372 111.00	372 111.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
12	Сандал /түшлэгтэй/	7	ш	9	42 350.00	381 150.00	381 150.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
13	Кнескоп	7	ш	1	109 990.00	109 990.00	109 990.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
14	Диван	16	ш	1	815 000.00	815 000.00	815 000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	татах	татах
15	Зүүдэг тумбочка	10	ш	1	75 000.00	75 000.00	75 000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
16	Хивс	37	ш	2	141 102.00	282 204.00	282 204.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах	устгах
Тавилга, эд хогшлын дүн						3 507 515.00	3 507 515.00	-					
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						165 490 915.00	165 490 915.00	0.00					
Үүнээс Татан төвлөрүүлэх хөрөнгө						164 431 210	164 431 210	-					
Актлах хөрөнгө						1 059 705	1 059 705	-					